

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМГИЙН АХМАДЫН ХОРООНЫ 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/122/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2021 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Х
khovd@audit.gov.mn
Аудитын менежер:
Утас: 70432545 Цахим хаяг:
Тунгалаг бүртгэл Аудит ХХК
Аудитор: Ч.Мөнхцооз
Утас: 99028555
Цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
4. Менежментийн захидал	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



АЙМГИЙН АХМАДЫН ХОРОО
ДАРГА Ч.ДАМБАДАРЖАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Ахмадын хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ахмадын хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, ахмадуудын эрх ашгийг хамгаалах, ахмадуудын хөдөлмөр эрхлэлтэнд дэмжлэг үзүүлэх, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг өргөжүүлэх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан агуулсан байна. удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

021020706

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,754,538.50</u>	<u>2,663,172.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,485.50	66,962.50
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	37,485.50	66,962.50
31110	Төгрөг	37,485.50	66,962.50
33	АВЛАГА	86943.00	0.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	86,943.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2630110.00	2596210.00
354	Хангамжийн материал	2630110.00	2596210.00
35410	Бичиг хэргийн материал	44,000.00	66,000.00
35420	Аж ахуйн материал	1,608,610.00	2,530,210.00
35440	Түлш, шатах тослох материал	977,500.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,303,163.33</u>	<u>22,061,590.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,303,163.33	22,061,590.00
392	Биет хөрөнгө	7,303,163.33	13,061,590.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,086,800.00	17,556,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	4,591,950.00	7,692,733.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,411,410.00	6,411,410.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	2,603,096.67	3,213,886.67
393	Биет бус хөрөнгө	9,000,000.00	9,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,000,000.00	9,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>19,057,701.83</u>	<u>24,724,762.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>100,955.97</u>	<u>5,646,513.97</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,955.97	5,646,513.97
413	Өглөг	100,955.97	5,646,513.97
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	100,955.97	308,407.97
4136	Бусад өглөг	0.00	5338106.00
41361	Байгууллагад төлөх өглөг		5338106.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>18956745.86</u>	<u>19078248.53</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	18956745.86	19078248.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11018198.00	11018198.00
512	Хуримтлагдсан үр дүн	7904277.86	8025780.53
51210	Өмнөх үеийн үр дүн	8,760,524.76	7,904,277.86
51220	Тайлант үеийн үр дүн	-856,246.90	121,502.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,270.00	34,270.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>19057701.83</u>	<u>24724762.50</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	72,498,600.00	76,238,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,798,600.00	63,248,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	62,798,600.00	63,248,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,798,600.00	63,248,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,798,600.00	63,248,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,700,000.00	12,990,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,700,000.00	12,990,000.00

Аймгийн Ахмадын хорооны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,700,000.00	12,990,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	73,354,846.90	76,116,697.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,354,846.90	76,116,697.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,649,094.90	75,369,697.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,285,124.00	44,492,716.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,285,124.00	44,492,716.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,671,908.90	5,380,655.00
210201	Тэтгэврийн даатгал	4,671,908.90	5,380,655.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,801,899.00	14,731,409.00
210301	Гэрэл, цахилгаан	138,811.00	72,803.00
210302	Түлш, халаалт	7,177,500.00	14,170,606.00
210303	Цэвэр, бохир ус	2,485,588.00	488,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,819,723.00	2,882,844.00
210401	Бичиг хэрэг	830,900.00	958,800.00
210402	Тээвэр, шатахуун	770,735.00	76,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,061,988.00	815,414.00
210404	Ном, хэвлэл	186,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	200,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,595,100.00	712,630.00
2107	Томилолт, зочны зардал	816,600.00	24,000.00
210702	Дотоод албан томилолт	816,600.00	24,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	697,600.00	151,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	82,600.00	63,500.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	415,000.00	88,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,556,240.00	7,706,573.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,503,000.00	3,995,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,053,240.00	3,711,573.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,705,752.00	747,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,705,752.00	747,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,705,752.00	747,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(856,246.90)	121,502.67

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	72498600.00	76238200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,798,600.00	76,238,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	62,798,600.00	76,238,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,798,600.00	76,238,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,798,600.00	76,238,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9700000.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9700000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9700000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	72,479,777.00	76,208,723.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,479,777.00	66,738,723.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,937,025.00	65,991,723.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,260,794.10	44,198,321.00

210105	Гэрээт ажлын хөлс	38,260,794.10	44,198,321.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,671,908.90	5,380,655.00
210201	Тэтгэврийн даатгал	4,671,908.90	5,380,655.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,779,399.00	8,415,803.00
210301	Гэрэл, цахилгаан	138,811.00	72,803.00
210302	Түлш, халаалт	8,155,000.00	7,855,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,485,588.00	488,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,044,723.00	3,826,444.00
210401	Бичиг хэрэг	874,900.00	980,800.00
210402	Тээвэр, шатахуун	770,735.00	76,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,061,988.00	815,414.00
210404	Ном, хэвлэл	186,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	200,000.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	1,776,100.00	1,634,230.00
2107	Томилолт, зочны зардал	780,600.00	24,000.00
210702	Дотоод албан томилолт	780,600.00	24,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	697,600.00	151,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	415,000.00	88,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	82,600.00	63,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,702,000.00	3,995,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,702,000.00	3,995,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,542,752.00	747,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,542,752.00	747,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	80,752.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,462,000.00	747,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18823.00	29477.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	9,470,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	9,470,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	9,470,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	9,470,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-9470000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18823.00	29477.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,662.50	37,485.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,485.50	66,962.50

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,018,198.00	34,270.00	8,760,524.76	0.00	19,812,992.76
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,018,198.00	34,270.00	8,760,524.76	0.00	19,812,992.76
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-856,246.90	0.00	-856,246.90
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,018,198.00	34,270.00	7,904,277.86	0.00	18,956,745.86
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,018,198.00	34,270.00	7,904,277.86	0.00	18,956,745.86
D08	Тайлант үеийн үр дүн			121,502.67		121,502.67
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,018,198.00	34,270.00	8,025,780.53	0.00	19,078,248.53

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны төлөвлөгөө	Гүйцэтгэл
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	63,605,700.00	63,218,723.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,605,700.00	63,218,723.00
Цалин нэмэгдэл урамшил	38,864,500.00	44,198,321.00
Үндсэн цалингийн зардал	38,864,500.00	44,198,321.00
Нийгмийн даатгалын шимтгэл	4,858,600.00	5,380,655.00
тэтгэврийн даатгал	4,858,600.00	5,380,655.00
Байр ашиглалттай холбоотой зардал	15,680,200.00	8,415,803.00
Гэрэл, цахилгаан	2,498,100.00	72,803.00
Тулш, халаалт	10,241,800.00	7,855,000.00
Цэвэр бохир ус	2,940,300.00	488,000.00
Хангамж бараа материал	3,824,100.00	2,949,444.00
Бичиг хэрэг	980,800.00	980,800.00
Тээвэр шатхуун	76,000.00	76,000.00
Шуудан интернетийн зардал	1,690,000.00	815,414.00
Ном хэвлэл	120,000.00	120,000.00
Хог хаягдал зайлуулах хортон мэргэчдийн устгал	200,000.00	200,000.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	757,300.00	757,230.00
Томилолт зочины зардал	-	24,000.00
Дотоод албан томилолт /Арга хэмжээ/		24,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	-	151,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		88,000.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		63,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	378,300.00	1,352,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	378,300.00	1,352,000.00
Урсгал шилжүүлэг	-	747,000.00
Бусад урсгал шилжүүлэг		747,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		747,000.00
САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,605,700.00	63,248,200.00
- Санхүүжилт	63,605,700.00	63,248,200.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэмэлт санхүүжилт байхгүй

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Аймгийн Ахмадын хорооны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Ч.Дамбадаржаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 2 дугаар сарын 08-наас 2021 оны 02 дугаар сарын 14–ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцооз нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх, ахмадуудыг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах тэднийг хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх ажлыг гол зорилгоо болгон ажиллажээ.

Аймгийн хэмжээний ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл хөтөлбөрт ахмадуудыг хамруулах

Ахмад чөлөөт эмч нарын төрийн бус байгууллагатай хамтран ахмадуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх өдрийн болон явуулын үйлчилгээнд хамруулах зорилтуудыг хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн Ахмадын хорооны удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хяналт хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 76116,6 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 761,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аймгийн Ахмадын хорооны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5637,5 мянган төгрөгөөр буюу 29,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
мөнгөн хөрөнгө	37,486	66,963	29,477
Авлага	86,943	-	-86,943
Бараа материал	2,630,110	2,596,210	-33,900
Үндсэн хөрөнгө	16,303,163	22,061,590	5,758,427
Нийт хөрөнгө	19,020,216	24,657,800	5,637,584
Өр төлбөр	100,956	5,646,514	5,545,558
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	18,919,260	19,011,286	92,026
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	19,020,216	24,657,800	5,637,584

Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, өр төлбөр дансдын үлдэгдэл материаллаг дүнгээр өссөн бөгөөд үндсэн хөрөнгө данс орон нутгийн хөрөнгө оруулалтаар ахмадын хөгжлийн танхимын тохижилтод зориулан проектор, 32 инчийн 4 ширхэг зурагт, ус цэвэршүүлэгч, массажны аппарат зэрэг 9470,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдэж, 3711,5 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурч дүнгээрээ 5758,5 мянган төгрөгөөр өссөн байна.

Харин өр төлбөрийн дүн 5545,5 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онуудад нам даралтын зуухаар халааж байсан бол тайлант жилд төвлөрсөн шугамаас халаалт авахаар болсонтой холбоотой халаалтын өр үүссэн байна. Халаалтын төсөв батлагдаагүй, цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч тусгаарлах байрны зориулалтаар бэлтгэгдсэн зэрэг нөхцөл байдлаас халаалтын өрийн асуудлыг тайлангийн хугацаанд шийдэж чадаагүй байна.

Хүснэгт 2 Орлогын үзүүлэлтүүд

Ахмадын хорооны нийт орлого өмнөх оноос 3739,6 мянган төгрөгөөр буюу 5,1 хувиар өсжээ.

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт	62,798,600	63,248,200	449,600
Засаг даргын нөөц хөрөнгө	9,700,000	12,990,000	3,290,000
Үйл ажиллагааны орлогын дүн	72,498,600	76,238,200	3,739,600

Орон нутгийн төсвийн санхүүжилт 449,6 мянган төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс хуваарилсан дэмжлэг 3290,0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 3 Зардлын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
гэрээт ажлын хөлс болон НДШ	42,957,033	49,873,371	6,916,338
Байр ашиглалттай холбоотой зардал	9,801,899	14,731,409	4,929,510
Хангамж бараа материалын зардал	4,819,723	2,882,844	(1,936,879)
Бусад бараа үйлчилгээний зардал	15,776,192	8,629,073	(7,147,119)
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	73,354,847	76,116,697	2,761,851

Нийт зардал өмнөх оноос 2761,8 мянган төгрөгөөр буюу 3,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 6916,3 өссөн нь цалингийн нэмэгдэх өөрчлөлт орсноос, байр ашиглалтын зардал 4929,5 мянган төгрөгөөр өссөн нь халаалт төвлөрсөн шугамтай холбогдсоноос зардал нэмэгдсэнээс хамаарсан байна. Харин бараа материалын болон бусад бараа үйлчилгээний зардал 1936,8-7147,1 мянган төгрөгөөр тус тус буурчээ. Бууралт нь үйл ажиллагааны хязгаарлалттай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 63605.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 63605.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 63605,7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 63605,7 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 63248.2 олгожээ.

Халамжаас ахмадуудын урамшуулалд 3000.0 мянган төгрөг орж ирснээс Зэрэг сумын ахмадын байгууллага руу 2000.0 үлдэх 1000.0 мянган төгрөгийг Жаргалант сумын ахмадуудын дунд уулзалт үдэшлэг зохион байгуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс ахмадын хөгжлийн танхимын тохижилтод зориулан 9990.0 мянган төгрөг олгожээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ахмадын хорооны нэмэлт дансаар ажил гүйлгээ гараагүй

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлан тооцоонд батлагдсан маягт хэрэглэж анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх зөвлөмж өгсөн нь бүрэн хэрэгжээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар материаллаг дүн бүхий алдаа илрээгүй бөгөөд эд хариуцагчийн тайлан гаргалт, тооллого тооцоо бодолтын талаар журам заавар мөрдөөгүйтэй холбоотой зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа гараагүй.

- Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа байхгүй

- Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:

Ахмадын хорооны барилга өөрийн данс бүртгэлд байдаггүй боловч газар нь данс бүртгэлд байна. Иймээс үл хөдлөх хөрөнгийг газрын хамтаар данс бүртгэлд тусгах нь зүйтэй байх.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал.

1.1. **Илрүүлэлт:** Эд хариуцагч хавсран гүйцэтгэдэг бөгөөд эд тайлан тооцоог актаар баталгаажуулаагүй байна.

1.2. **Эрсдэл:** Төсвийн үрэлгэн зарцуулалт үүсэх

1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.3-д заасан зохистой удирдлага, хариуцлагатай байдлыг хангаж ажиллах

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна.

2.1. **Илрүүлэлт:** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

2.2. **Эрсдэл:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар** Зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Аймгийн ахмадын хорооны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/122/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Аймгийн ахмадын хороо		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эд хариуцагч хавсран гүйцэтгэдэг бөгөөд эд тайлан тооцоог актаар баталгаажуулаагүй	00	Зөвлөмж	Ахмадын хорооны дарга Ня-бо	Дамбадаржаа
2	Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу	00	Зөвлөмж		
ДҮН		00			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР